

## 3

### ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨНД УЛСЫН ЗАРДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Д.Ганзориг

Улс орнууд дэлхийн эдийн засагт татагдан орох үйл явц хүчтэй өрнөж буй энэ зуунд эдийн засгийн өсөлтийн зүй тогтол, механизмыг судлаж амьдрал, практикт хэрэгжүүлэх явдал тулгамдсан асуудал болж байна. Зах зээлийн эдийн засагт шилжиж буй улс орнуудад нийтлэг хэрэгжиж байгаа улсын санхүүг тогтвортжуулах, эдийн засгийг бүхэлд нь либералчлах, эдийн засгийг нээлттэй болгох, хувьчлалыг өрнүүлэх зэрэг арга хэмжээнүүд нь шинэчлэлийн гол цөм болж байгаа билээ. Гэвч дээрх арга хэмжээнүүдийг цогц байдлаар шийдвэрлэх үү, эсвэл дэс дараалалтай хэрэгжүүлэх үү, ер нь өөрчлөн байгуулалтын хурдац, хамрах хүрээг яаж авч үзэх зэрэг хэд хэдэн асуудалд одоо хүртэл цэгцтэй хариу бүрэн өгч чадахгүй, эрдэмтэд, судлаачид толгойгоо гашилгаж байна.

Тухайлбал, АНУ-ын эрдэмтэн Дж. Сакс эдийн засгийн нээлттэй бодлогод тэргүүлэх ач холбогдол өгч, түүнийг хэрэгжүүлэхгүйгээр эдийн засгийн тогтвортой өсөлт, хурдцыг хангаж чадахгүй гэж үздэг. Гэтэл 1997-1998 онд дэлхийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал нь нээлттэй бодлого тэр бүр амжилтанд хүргэдэгтүй болохыг нотлож өглөө. Дэлхийн эдийн засагт капиталын урсгал маш хүчтэй явагдаж буй өнөөгийн эрин үед гадаад эдийн засгийн харилцаа нь ядуу болон хөгжиж буй улс орнуудын эдийн засгийг тогтвортгүй болгодгийг бид мэдэж авлаа.

Мөн ОХУ-ын эрдэмтэн А.Илларианов эдийн засгийн өсөлтийн гол нөхцөл бол инфляци болон улсын зардлыг аль болохоор бууруулах явдал мөн гэж үзэж байна. Мэдээж хэрэг, өндөр инфляци бол хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөө үзүүлдэг нь ойлгомжтой. Гэхдээ инфляци бага байх тутам эдийн засгийн өсөлт өндөр байна гэдэг тодорхойлолтын талаар дэлхийн банкны мэргэжилтнүүд шүүмжлэлтэй хандаж байна. Дэлхийн банкны дэд өрөнхийлөгч М.Бруно нилээд өргөн судалгаа хийснийхээ үндсэн дээр инфляцийн босго байна гээд инфляци 20% хүртэл байхад эдийн засгийн өсөлтийг хангаж болно гэж дүгнэжээ.

Түүнчлэн эрх зүйн болон төсвийн механизмаар дамжуулан зах зээлийг зохицуулахад төрийн оролцоо ямар байх талаар эрдэмтэд судалгаа явуулж байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг илэрхийлэх гол үзүүлэлт болох дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) динамик ба улсын зардлын хоорондын уялдаа, холбооны тухай асуудал юм. Энэ асуудлаар судлаачдын санал хоёр хэсэгт хуваагдаж байна. Нэг хэсэг эрдэмтэд ДНБ-нд эзлэх улсын зардлын хувь хэмжээ аль болох бага байх тутам эдийн засгийн өсөлт илүү түргэн байна гэж үздэг. Нөгөө хэсэг эрдэмтэд ДНБ-нд эзлэх улсын зардлын хэмжээ нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх нь бага, зарим талаар зөрөг нөлөө үзүүлдэг гэж үзэж байна. Ер нь ихэнх эрдэмтэд нэг дэх чиглэлийг баримталдаг учир бид хоёр дахь чиглэл дээр тогтох ярья. Эрдэмтдийн хийсэн судалгаанаас үзвэл, 19-р зуунд тэр үеийн хөгжилтэй улс орнуудын ДНБ-нд улсын зардлын эзлэх хувь хэмжээ 7-14 хувьтай байжээ. Харин 20-р зуунд Баруун Европ, АНУ, Японд дээрх үзүүлэлт 4-5 дахин нэмэгджээ.

Дээрх хугацаанд нэг хүн амд ногдох ДНБ-ний жилийн дундаж хурдац 09-1.1 хувьтай байснаа 2.2-2.3 хувь болж 2 дахин өссөн байна. Эндээс үзвэл, ДНБ-нд эзлэх улсын зардлын хэмжээ ямар нэг хувиар өсөхөд ДНБ болон нэг хүн амд ногдох ДНБ хэдий хэмжээгээр өсөх вэ, тэдгээрийн хооронд тогтвортой холбоо байгаа эсэх, ямар хүчин зүйлүүд тэдгээрт нөлөөлж байна вэ гэсэн асуудлууд зүй ёсоор урган гарна.

Дээрх судалгаанаас үзвэл, 20-р зуунд хөгжилтэй улс орнуудад дээрх хоёр үзүүлэлтийн хамаарал зөрөг байсан нь харагдаж байна. Энэ нь улсын зардлыг аль болохоор багасгах чиглэл барьдаг эрдэмтдэд нэгийг бодогдуулах болов уу. Дэлхийн тэргүүлэгч 7 орны ДНБ-нд эзлэх улсын зардлын эзлэх хувь хэмжээ 1950-1996 онуудад 3/4 дахин нэмэгдэж, дунджаар 45-46 хувьд хүрчээ (График 1).

График 1



Дээрх хугацаанд хөгжилтэй улс орнууд улсын зардлыг эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийг бүрдүүлэх, боловсролыг хөгжүүлэх, эрүүл мэндийн салбарыг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулахад зарцуулсан байна.

Энэ бүхнээс үзвэл, зарим эрдэмтэд улсын зардлын эзлэх хувь болон ДНБ-ний динамикийн хооронд нилээд бат бэх бөгөөд сөрөг холбоо байдаг гэж үздэг боловч шинжилгээнээс үзвэл дээрх хоёр хэмжигдэхүүний хооронд тогтвортой бөгөөд бат бэх уялдаа холбоо байдаггүй, зарим үед эерэг утгатай байдаг нь харагдаж байна. Сүүлийн 100-130 жилд Баруун Европын орнууд болон Японы ДНБ-ний динамик ба улсын зардлын эзлэх хувь хэмжээ хоорондоо эерэг утгатай байжээ.

Мөн хөгжилтэй орнуудын ДНБ-нд улсын зардлын эзлэх хувь хэмжээ 45 хувь хүртэл өссөн хэдий ч тэр нь эдийн засгийн өсөлтийг сааруулсан гэж үзэх үндэс бага байна. Гэхдээ дээрх үзүүлэлт 55-65 хувьд хүрсэн үед ДНБ-ний өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлсэн болохыг Швед, Нидерланд улсын туршлага харуулж байна. Эндээс үзвэл, ДНБ-нд улсын зардлын эзлэх хувь хэмжээг оновчтой тогтоох, өөрөөр хэлбэл, энэ үзүүлэлтийн босгыг тодорхойлох асуудал урган гарч байна. Бидний үзэж байгаагаар, ДНБ-нд улсын зардлын эзлэх хувь хэмжээ 50 хүртэл хувьтай байх нөхцөлд эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй болов уу.

Ер нь 80-90-ээд онд улсын зардлын (хэрэглээ) нийт хэмжээ хөгжилтэй орнуудад байж болох дээд түвшиндээ хүрсэн байна. Энэ үед ДНБ-нд эзлэх хэрэглээ ба хөрөнгө оруулалтын хувь хэмжээний хоорондын хамаарал сөрөг утгатай байсан ба тэр нь бүр ихэссэн байна. Хөгжилтэй 19 оронд хийсэн судалгаанаас үзвэл, дээрх хоёр үзүүлэлтийн корроляци 1960 онд -0.29 байснаа 1980 онд -0.6 болж өсчээ. Ийнхүү улсын зардал өссөнөөр хөрөнгө оруулалтыг (ялангуяа хувийн хөрөнгө оруулалтыг) дэмжих явдалд саад бэрхшээлийг учруулах болсон гэж судлаачид үздэгийг энд дурьдах нь зүйтэй болов уу.

Мөн 70-90 онд хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсвөлт саарсан нь үндэсний тооцооны уламжлалт системтэй холбоотой гэж нилээд эрдэмтэд үзэж байна. Гуравдагч секторын ХБ өсөлт, бүтээгдэхүүний чанарыг тооцож чадахгүй байгаа, нөгөө талаар дефляторыг өсгөн тооцож байгаагаас ДНБ-ний өсөлтийн хурдцыг 0.6-1.5 пунктээр бууруулж тооцож байна гэж тэд шүүмжлэх болов.

Энэ судалгааны үр дүнг анхааралдаа авч, бага хэмжээгээр ч болов бүтээгдэхүүн, таваар ба үйлчилгээний чанарын өсөлтийг тооцоонд оруулж, мөн тэргүүлэгч орнуудын мэдээлэл-шинэчлэлийн потенциалыг мөн тооцож чадвал байдал өөр байх нь тодорхой. Шинэ ба шинэлэг салбарууд хурдан хөгжснөөр нийт эдийн засгийн өсөлтийг урамшуулж байна. Үүнд төрөөс хангалттай оролцсон. Тэр нь үр дүнгээ өгч байна. Хэдийгээр улсын зардал нь ямар нэг хэмжээгээр капиталын хуриатлал болон эдийн засгийн хөгжилд саад учруулж байгаа боловч шинэ эрэлтийг бий болгож өргөжүүлснээр, ялангуяа нийгмийн арга хэмжээ, хүний хүчин

зүйлд хөрөнгө оруулалт хийснээр эерэг нөлөөллийг бий болгон улмаар эдийн засгийн хөгжилд нааштай нөхцлийг бүрдүүлж байна.

Улсын зардлыг өсгөх хамгийн гол хүчин зүйлсийг авч үзье. ХХ зуунд урьд байгаа гүй хэмжээгээр хүмүүн капиталд онцгой анхаарал тавьж эдийн засгийг нийгмжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлж ирсэн билээ. Ийнхүү нийгмийн хангамж, нийгмийн дэд бүтцийг өргөжүүлэх, шинэчлэх болон боловсрол, эрүүл мэндийг хамгаалахад зориулсан улсын зардлын эзлэх хувь хэмжээг нэмэгдэхүүцээр дээшлүүлсэн байна. Хөгжилтэй орнуудын ДНБ-нд эзлэх нийгмийн зардлын эзлэх хувь хэмжээ 1960 онд 10 орчим хувь байсан бол 1990-ээд онд 20-25 хувь өсчээ. Өндөр хөгжилтэй орнуудын улсын төсөвт нийгмийн зардлын эзлэх хувь 1960 онд дунджаар 13% байсан бол 1992 онд 26% болжээ. Энэ хугацаанд нэг хүн амд ногдох ДНБ-ний жилийн дундаж өсөлтийн хурдац 2.4-2.5% байв.

Улс орнууд сүүлийн 30-40 жилд нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хөрөнгө оруулж ингэснээр ДНБ-нд эзлэх нийгмийн зардал өссөн нь эдийн засгийн өсөлт, хөгжилд сөрөг нөлөөлөөгүй болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Тодруулбал, 20 зуунд өнөөгийн өндөр хөгжилтэй орнуудад боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаанд зориулсан зардал 2/3-3/4 дахин нэмэгдэж улмаар улсын зардлыг өсгесэн ажээ. Дээрх арга хэмжээний үр дүнд хүмүүн капиталыг ихээхэн идэвхжүүлж чадсанаар 1950-1990-ээд онуудад хөгжингүй улс орнуудын ДНБ-ийг 1/3-1/5 дахин өсгөх боломжийг бүрдүүлсэн байна.

Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжилт хийж, энэхүү үйл явц одоо хүртэл үргэлжилж байна.

#### Эдийн засгийн үзүүлэлт

Хүснэгт 1

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
ДНБ-ны жилийн дундаж өсөлт	-9.5	-3.0	2.3	6.3	2.4	3.3	3.5	3.5
Инфляцийн жилийн өсөлт	325.5	183.0	66.3	53.3	53.2	17.5	6.0	10.0

Хүснэгт 1-ээс үзэхэд 1992 онд ДНБ-ний бууралтын хурд болон инфляцийн түвшин дээд цэгтээ хүрчээ. 1993 онд ДНБ-ний нэг хүнд ногдох хэмжээ буурч 1989 оны 3/4 тэнцэх хэмжээнд хүрч очжээ. Ийнхүү манай зарим эрдэмтдийн хэлсэнчлэн эдийн засаг "бодит хөрсөн" дээр буусан байна.

Харин 1994 оноос сэргэлт явагдаж ДНБ өсчээ. Энэ хугацаанд инфляцийн түвшин байнга буурч 1998 онд нэг оронтой тоонд шилжив. Хэдийгээр 1994-1996 онд

инфляцийн түвшин харьцангуй өндөр байсан ч ДНБ ёссөн байна. Ялангуяа 1995 онд ДНБ-ний өсөлт 6.3 хувьд хүрчээ. Эндээс үзвэл, манайд инфляцийн түвшин өндөр байхад ч эдийн засгийн өсөлт гарсан нь тодорхой харагдаж байна.

Монгол улсын хувьд ДНБ ба түүнд улсын зардлын эзлэх хувь хэмжээ ямар түвшинд байгааг авч үзье.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд  
улсын зардлын эзлэх хувь

Хүснэгт 2

	1993	1994	1995	1996	1997	1998	1999
ДНБ-нд нийт Зарлагын эзлэх хувь	52.5	44.2	40.4	36.0	37.9	39.1	38.7

Хүснэгтээс үзвэл, 1993 онд ДНБ-нд улсын зардлын эзлэх хувь 50 хувиас дээш байсан бөгөөд энэ үед ДНБ буурсан нь ажиглагдаж байна. Харин 1994 оноос улсын зардлын эзлэх хувь хэмжээ ч ерөнхийдөө буурч энэ нь ч ДНБ-ний өсөлтөнд зэрэг нөлөө үзүүлжээ. Хүснэгт 2-т үзүүлсэн тоо материалаас үзвэл, ДНБ-нд эзлэх улсын зардлын эзлэх хувь 30-40 хувьд байхад улс орны эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

Улсаас зарцуулж буй нийт зардалд чухамхуу зардлын аль статья гол үүрэгтэй байгааг тодорхойлох нь бидний сонирхлыг татах нь мэдээж. Манай улсын статистикийн тоо материалаас үзэхэд, 1993 оны байдлаар нийгмийн арга хэмжээнд зориулсан зардлын ДНБ-д эзлэх хувь 18.6% байсан бол 1997 оны байдлаар 22%-д хүрсэн тоо мэдээ байна. Ийнхүү төрөөс нийгмийн арга хэмжээнд зориулсан зардлын хэмжээ өсөх хандлагатай байна. Бидний хийсэн дээрх судалгааг нэгтгэн авч үзвэл, шилжилтийн эдийн засаг бүхий манай орны хувьд төрийн оролцоо ерөнхийдөө хангалттай байсан нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Ер нь инфляцийн түвшин, ДНБ-нд эзлэх улсын зардлын хувь хэмжээний босгыг зөв тодорхойлж, оновчтой хувилбарт барьж төрөөс эдийн засгийг удирдах нь нийгмийн бодлогыг тэргүүлэх чиглэл болгож буй өнөөгийн засгийн газрын тулгамдсан зорилт болж байна.

## Ашигласан ном, хэвлэл

1. Sachs.J, Warner.A. Economic Reform and the Process of Global Integration Harward Institute for International Development Papir №552. Sept. 1996.
2. Bruno.M. Does Inflation Really Lower Growth? – Finance and Development Wash. Sept. 1995 p. 35.
3. А.Илларианов. Лекарство от спада (Известия 1996. 19 сентября)
4. Мировая экономика и международные отношения 1999. №10.
5. Монголын хөгжлийн стратеги УБ.1999. № 31-50.
6. ХХI зууны босгон дээрх Монгол улсын шинэчлэл, цаашдын хөгжлийн хандлагууд УБ. 2000. № 37-66.
7. Монгол улсын статистикийн эмхтгэл УБ. 2000.